

## ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд “соёлын” болон “байгалийн” өвийн<sup>1</sup> холбогдолтой дараах 6-н төрөл зүйлийн<sup>2</sup> түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс<sup>3</sup> хамрагдсан. Үүнд:

- Түүхийн холбогдолтой 403 хосгүй үнэт дурсгалт зүйл (51.7%),
- Шашин шүтлэгийн холбогдолтой 274 хосгүй үнэт дурсгалт зүйл (35.2%),
- Археологийн холбогдолтой 48 хосгүй үнэт дурсгалт зүйл (6.1%),
- Байгалийн өвийн холбогдолтой 34 хосгүй үнэт дурсгалт зүйл (4.3%),
- Урлаг, уран сайхны холбогдолтой 11 хосгүй үнэт дурсгалт зүйл (1.4%),
- Угсаатны зүйн холбогдолтой 8 хосгүй үнэт дурсгалт зүйл (1.02%) тус тус байна (Зураг №1).



Зураг №1. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт (1995-2019)

<sup>1</sup> ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар 1972 оны 11 дүгээр сарын 16-нд батлагдсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийн конвенци”-ийн нэгдүгээр бүлгийн 1 ба 2 дугаар зүйл.

<sup>2</sup> Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн төрөл зүйлийн ангиллаар.

<sup>3</sup> Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн ангилал, зэрэглэлийн тухай хоёрдугаар бүлгийн 6.1 дүгээрт заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ангиллаар.

▪ “Түүхийн холбогдолтой” төрөл зүйлд 403 хосгүй үнэт дурсгалт зүйл хамрагдаж байгаа нь нийт хосгүй үнэт дурсгалт зүйлийн 51.7%-ийг эзэлж байна. “Түүхийн холбогдолтой” 403 хосгүй үнэт дурсгалт зүйлийн:

- Зоос мөнгөн тэмдэгт 316 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Түүхэн бие хүний холбогдолтой 63 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Ном хэвлэл, бичгийн холбогдолтой 21 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Билэгдэл, таних тэмдгийн холбогдолтой 2 хосгүй үнэт дурсгалт зүйл дурсгалт зүйл тус тус байна.


Энэхүү “түүхийн холбогдолтой” төрөл зүйл дотроо хамгийн их хувийг эзэлж байгаа 315 ширхэг зоос мөнгөн тэмдэгт нь гадны хийгээд манай улсад харьцангуй нийтлэг элбэг олдцотой байдаг монголын бага хаадын үед хамаарах зооснууд байна (Зураг №2).



Зураг №2. Түүхийн холбогдолтой 403 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл

▪ Хосгүй үнэт дурсгалт зүйлийн нийт төрөл зүйлийн 35.2%-ийг “шашин шүтлэгийн” холбогдолтой төрөл зүйл эзлэх ба уг төрөл зүйлд 274 хосгүй үнэт дурсгалт зүйл байна (Зураг №3). Үүнд:


- Шүтээн урлалын цутгамал 133 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Танка зураг 67 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Зээгт намаал, танка зургийн 35 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Хөөмөл урлалын 23 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Сийлбэр урлалын 6 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Цамын баг, өмсгөлийн 6 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Шашны зан уйлийн холбогдолтой 2 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Баримал шуумлын урлалын 1 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Шашны хөгжмийн зэмсэг 1 хосгүй үнэт дурсгалт зүйл байна.



Зураг №3. Шашин шүтлэгийн холбогдолтой 274 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл.

▪ Археологийн төрөл зүйлд 48 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл байгаа нь нийт хосгүй үнэт дурсгалт зүйлийн 6.1%-ийг эзэлж байна (Зураг №4). Үүнд:

- Гоёл чимэглэлийн холбогдолтой 22 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Хувцас хэрэглэл 11 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Чулуун дурсгал 5 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Зэр зэвсэг байлдааны холбогдолтой 4 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Ахуй хэрэглээний холбогдолтой 4 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Хөгжмийн зэмсэг 1 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Шүтлэг зан үйлийн холбогдолтой 1 хосгүй үнэт дурсгалт зүйл тус тус байна.



Зураг №4. Археологийн холбогдолтой 48 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл

▪ Байгалийн өвийн төрөл зүйлд 34 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл байгаа нь нийт дурсгалын 4.3% болж байна (Зураг №5). Үүнд:

- Палеонтологийн олдвор 26 хосгүй үнэт дурсгалт зүйл,
- Солир 7 хосгүй үнэт дурсгалт зүйл ,
- Геологийн баялаг, ашигт малтмалын дээжис 1 хосгүй үнэт дурсгалт зүйл тус тус байна.



Зураг №5. Байгалийн өвийн холбогдолтой 34 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл.

▪ Урлаг, уран сайхны төрөл зүйл хамрагдсан 11 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл нь нийт дурсгалын 1.4% болох ба үүнд монгол зураг 6 хосгүй үнэт, уран зураг 5 хосгүй үнэт тус тус байна (Зураг №6).



Зураг №6. Урлаг, уран сайхны холбогдолтой 11 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл

▪ Угсаатны зүйн төрөл зүйлд 8 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл буюу нийт хосгүй үнэт дурсгалт зүйлсийн хамгийн бага 1.02%-ийг эзэлж байна. Угсаатны зүйн төрөл зүйлд дээл хувцас, гоёл чимэглэлийн холбогдолтой 5 хосгүй үнэт, гэр зуурын үйлдвэрлэл, гар урлалын холбогдолтой 2 хосгүй үнэт, мал аж ахуй, уналга тээврийн холбогдолтой 1 хосгүй үнэт дурсгалт зүйл зүйл тус тус байна (Зураг №7).



Зураг №7. Угсаатны зүйн холбогдолтой 8 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл

---хХх---